



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/294

Номгон

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд,
боловсрол, нийгмийн хамгааллын комиссын
үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1а, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2021 оны үйл ажиллагаанд зарцуулах 705.000 /долоон зуун таван мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

621010751